

«МОНГОЛ ҮГИЙН БОДОРЛ»-ЫН ТУХАЙ

Оюун*

* Өвөр Монголын Их Сургуулийн сонин мэдээ, хэвлэлийн ухааны тэнхмийн эрхлэгч, дэд профессор Хөрвүүлсэн Л.Норовсүрэн

Түлхүүр үг: эрдэм сэтгэл, бодорол, орчуулах түшмэл, бичгийн сургаалтан, илэрхий цааз.

Хөх морин жилийн Дундад улс ба Японы дайн (1894-1895 он)-д Дундад улс ялагдаж, доройтон буурсан Чин гүрэн Япон лугаа Бээжингийн гэрээг тогтоожээ. Ингээд Дундад улсын нийгмийн хагас колоничлол ихэд гүнзгийрэв. Орос, Япон, Герман, Франц, Англи зэрэг хөгжсөн улсууд Дундад улсад банк байгуулах, албадлагаар зоос зээлүүлэх, төмөр замд бэл оруулах, уурхай малтаж үйлдвэр байгуулах хэлбэрээр түрэмгийллээ чангатгахын дагуу Дундадын газар нутгийг албадан түрээсэлсэн буюу хэсэглэн эзэлсэн байна. Иймэрхүү хэсэглэн хуваалцах урсгал дунд Орос ба Япон эрхшээлийн хүчээ Монгол оронд түржээ.

Тэд монгол хошуудын уурхай балгадаас их баялгийг тонож, Монголын ван гүн нарыг өдөөн хатгаж Дундад улсаас тусгаарлуулахаар оролдож байсан юм. Чин гүрнээс Орос ба Японы энэхүү ажиллагаанд чиглэгдэж, "Монгол үгийн бодорол" сэтгүүлийг "Нэгэн сард нэгэн удаа тархаан явуулж монгол ардын мэдэл чадлыг нэвтрүүлэн", "Хааны эрдэм сэтгэлийг ухуулан тархаах"¹-аар

дамжуулан монголчуудад улс гүрний ухамсрыг буй болгон, үүний улмаас Орос, Японы монгол орон дахь нөлөөний өргөжлийг хориглох ба Монгол орон дахь Дундад улсын эрх мэдлийг батлах зорилт тавьсан байна.

Нэг. "Монгол үгийн бодорол" сэтгүүлийн тухай

"Монгол үгийн бодорол" сэтгүүлийг бадаргуулт төрийн гучин дөрөвдүгээр (1908) оны дөрвөн сарын 15-нд "Гириний Дайчлан байцаах газар" (сүүлээр нь Монголын явдлыг шийтгэх газар)-аас 13х20 см-ийн хэмжээтэй, 52-100 хуудастай²-гаар монгол, хятад хоёр бичгээр хадмаллан, чулуун барын аргаар сар бүрийн арван таванд хэвлэж байв. Нийслэлийн Чен И, Гириний Чин Мэн, Мүгдэний Лу Хувэй Чин нар сэтгүүлийн тушаалыг баригч түшмэлээр, Иүй Чин, Гүвэ Шеү Чин, Ань Мин нар урьд хожид журмаар туслагч түшмэлийн хувиар хятад үсгийн найруулагчаар, Жен Сиян Чиеу, Ван Цэй Пен нар хятад үсгийн бичигчээр, Ма Жиен Сиюн зураг зурагчаар ажиллаж байжээ.

Монгол хятад үсэг орчуулах түшмэл ба туслан орчуулах түшмэл жич монгол үсэг бичигчээр Соромбо, Ихдэчүн, Юүн

Чен, Шиен Юүн, Пу дэй, Их тунх нар ажиллаж байв³.

Сэтгүүлийн хавис (хавтас — Л.Н.)-ыг хээ угалзаар хөвөөлж, нэрийдлийг хятад монгол хоёр үсгээр дунд нь байршуулж, хэвлэсэн он, сар, өдөр, хэвлэсэн байгууллага ба сэтгүүлийн дугаарыг зүүн буюу баруун, эсхүл доод талд нь талбиж буй.

Сэтгүүл эрхлэх зорилтын тухай хэвлэл эхлэх үгэндээ: "Бид эдүгээ монгол үсгийн бодоролыг нэгэн дэвтэр шийтгэн гаргаж үүний эцэстээ ямар учир хэмээмүй, эдүгээ таван тивийн олон улсын иргэчүүд суртал чадал байхын тул сая дэлгэрүүлэн ухуулахыг мэдсэн ану ... гагц манай монгол газрын нэгэн төвийн хүмүүнийг дэлгэрүүлэн ухуулахад адбиш бэрх, тийнхүү гайхамшигтай болон чадахгүй болой... Үүнээс бус Рибен Орос аймаг лугаа байлдсаны хойно тийм нэгэн улс манжийн газар санаа сэтгэл нийцэхгүй хойш буцаж баруун хойт зүг эргээд эд ашиг ба тустай явдлыг эрж, бидний Монголын энэ мэт сайн газар тэднээ нэгдэн санаандаа боджухай... Бусад хүмүүн нар тань лугаа янаглан найртай болъё хэмээн ойртож, бас ч хэлэх ану. Бид бичиг суртал цөм адил бөгөөд бас ч нэгэн угсаа болмой хэмээн гаднаас үзвээс янаг найртай адил, түүний дотроо санасан ану манай монгол хүмүүн нарыг боолчууд болгон хэрэглэсүгэй хэмээн санамай... Үүнийг бид бас ч мэдэхгүй... Тэр гадаад улсын тэмцэлдэх хүчнийг үзвээс улам идэрхэгээр шахамдуулан байхыг хэрхэвчээр тэдний дураар манай монгол хүмүүнийг доромжлон булах буюу, харин ч нэгэн сайн аргыг үүсгэж олон бүхэнд тодорхойлон

мэдүүлбээс зохих атал, ийнхүү сая энэ нэгэн зүйлийн бодоролыг гаргаж энэ арвин монгол хүн ард нарт үсгийг таних ба үл танихыг ялгалгүйгээр энэ бодоролыг ухуулан гаргаваас нэгэн үсгийг таних хүмүүн дуудаж өгвөөс хэн хүмүүн бас ч энэ учир мэдэж болмой..."⁴ гэжээ.

Үүнээс Чин гүрний засгийн талаас монгол ардын ухаан мэдлийг "дэлгэрүүлэн", Орос ба Японы монголчуудыг өдөөн татаж Монгол орныг эрхшээх гэсэн "санаа"-г илчилж байгаад Дундад улсын Умард халхавч болсон Монгол орон дахь Орос, Японы нөлөөний өргөжлийг хориглох зорилтоор тус сэтгүүлийг эрхэлж байсныг тодорхой харах болно.

У г сэтгүүлд "Дээд зарлиг", "Богдын зарлигийг сэнхрүүлэн бадруулсан нь", "Хэлэлцсэн зүйл", "Цагийн хэргийн чухал сонсгол", "Гүехэн ойр сургаалыг хэлэлцсэн нь", "Элдэв юмны зүйл", "Айлтгасан учир", "Илүүц зүйл", "Зээлийн юмны үнэ", "Нэмсэн зураг" хэмээх байнгын булантай байж, аравдугаар удаагийн дэвтрээс хойш "Эртний явдал" хэмээх булан нэмжээ.

"ДЭЭД ЗАРЛИГ"-т "Илэрхий цааз байгуулсныг ухуулан тархаасан", "Монголыг номхотгох (илбэн амаржуулах)", "Монголын цасан аюулд тохиолдсоныг номхотгох", "Хар тамхи уухыг цаазалсан", "Далай ламыг угтсан", "Илэрхий цаазын хугацааг тархаасан" тухай хааны зарлигийг тэмдэглэн бичиж, Чин гүрний хаан ордноос монголчуудыг ивээн соёрхсон "эрдэм сэтгэл"-ийг сурталчилсан байдаг.

"БОГДЫН ЗАРЛИГИЙГ СЭНХРҮҮЛЭН БАДРУУЛСАН НЬ"-д бичгийн сургаалтан, богд мэргэдийн сургаалыг "тахимдах түүчээг хөгжүүлж, хүмүүний гол ёсо-

ныг хүндэтгэхүй нь", "Төрөл төрөгсдийг хүндэтгэж, янаг хайртайг илтгэхүй нь", "Гацаа хүйг найралдуулж, тэмцэх заалдахуйг байлгахуй нь", "Тариан илмийг эрхэмлэж, өмсөх идэхүйг хүрэлцүүлэхүй нь", "Арвилах хураахыг эрхэмлэж, эдийн хэрэглүүнийг хайрлахуй нь" гэх таван бүлэгт хуваан цувруулан нийтэлж, эцэг эхээ ачлах, ах дүүгээ дэмжих, ахмадыг хүндэтгэж, нялхсаа энэрэх, үгээгүй ядууг өршөөж, эв найрыг эрхэмлэх ба ажилч хөдөлмөрч байхыг сургаж байжээ.

«ШҮҮМЖЛЭН ХЭЛЭЛЦСЭН НЬ»-д монголчууд болон Манж Чингийн төр лугаа зан харьцааны тухай, мал аж ахуйгаа хэрхэн хөгжүүлэх

тухай, сурган хүмүүжлийг хүндэтгэх тухай, хар тамхийг цээрлэх тухай, монголчууд аж үйлс эрхлэх тухай, гадаад гүрэн лүгээ нөхөрлөхөд анхаарах тухай асуудлуудыг шүүмжлэн өгүүлж, монголчуудын ухаан мэдлийг нээхэд зориулагдаж байв.

«ЦАГИЙН ХЭРГИЙН ЧУХАЛ СОНСГОЛ»-д монгол газар банк гаргасан, цахилгаан чимээний газар байгуулсан, монгол ван сургууль байгуулсан, Монголын газрын зургийг зуруулсан, хаан ордноос монголчуудыг халамжилсан, Монголын цэргийн зэвсгийг байцаасан, Монголд уурхайн гаралт нээсэн, гадаадын мөнгийг үл зээлэх, монгол вангийн гадаадын өрийг орлон төлсөн, Далай ламыг угтан зочилсон, Монгол,

Төвдийн Засгийн хэргийг тэгшлэн зассан, хар тамхийг цаазалсан, Монгол орныг муж болгон өөрчлөн байгуулахыг бэлтгэсэн, Монголын аж үйлсийн компанийг байгуулсан, гадаадын жуулчлагчдыг зураг үл зуруулсан, Монгол оронд салхин цасны аюул болсон, засмал зам буюу төмөр зам зассан, англичууд Монгол оронд жуулчилсан, оросууд Монгол газраас мал худалдан авсан, япончууд Манж-Монголын арилжааны нийгэмлэг байгуулсан гэх мэтийн сонин мэдээг зохиогчийн уншсан 23-н хугацааны сэтгүүлд нийт 177 хувь нийтэлж, дугаар бүрд бараг 4-14

мэдээлэл буй. Үүнд дотоодын мэдээ олон тоог эзэлж, гадаадын мэдээ маш ховорхон буй. Агуулгын хувьд олонх нь Монгол орны улс төр, аж ахуй, сурган хүмүүжил, шашин суртахуунд холбогдож, гай гамшигийн тухай нийгмийн сонин мэдээ цөөхөн хэд л буй. Нийтэлсэн сонин мэдээллийн олонход нь хаан төрийн "эрдэм чадал", Монгол орныг эрхшээх гэсэн Орос, Японы ЗАРЛИГ (санаа)-ийг нэвчүүлэн шингээсэн нь гайхамшигтай байна.

«ГҮЕХЭН ОЙРЫН СУРГААЛЫГ ХЭЛЭЛЦСЭН НЬ»-д газрын байдлын сургаал (нэгдүгээрээс тавдугаар удаагийн дэвтэр, долоодугаар удаагийн дэвтэрт), тооны сургаал (хоёрдугаар удаагийн дэвтэр ба дөрөвдүгээрээс

«

Чин гүрний засгийн талаас монгол ардын ухаан мэдлийг "дэлгэрүүлэн", Орос ба Японы монголчуудыг одоон татаж Монгол орныг эрхшээх гэсэн "санаа"-г илчилж байгаад Дундад улсын Умард халхавч болсон Монгол орон дахь Орос, Японы нөлөөний өргөжлийг хориглох зорилгоор "Монгол үгийн бодорол" сэтгүүлийг эрхэлж байв.

»

зургаадугаар удаагийн дэвтэр болтол, наймдугаараас аравдугаар удаагийн дэвтэр болтол) жич тариалангийн сургаал (арваннэгдүгээрээс хоринтавдугаар удаагийн дэвтэр болтол) гэх газар зүй, тооны ухаан, тариалангийн ухааны мэдлэгийн зохиолыг нийтэлж, монголчуудад шинжлэх ухааны мэдлэгийг уламжилжээ. Ялангуяа "тариалангийн сургаал" хэмээх бүлэгт хөрсний онцлогоос эхлээд услах, үр сонгох, тарих, арчлах, бордоогоор ургуулах, хорхойтохыг сэргийлэх зэрэг аргыг нарийн танилцуулжээ.

«ЭЛДЭВ ЮМНЫ ЗҮЙЛ»-д голдуу «Хөдөөгийн туулай нүх ухсан нь», «Шиюү хэмээх шувуу жиу хэмээх шувуунд тохиолдсон нь», «Хөвгүүнийг сургасан нь», «Өөр арслан лугаа», «Шугуй мод», «Бүлэглэсэн шоргоолж», «Хараацай бялзуухай лугаа», «Ховдог сэтгэлийг цээрлэсэн нь», «Галууг алах нь», «Ховдог сэтгэлт арслан», «Мунхаг илжиг», «Чоно адгуусыг барьсан нь», «Үнэг ирвэсийн сайхныг тэмцэлдсэн», «Шувуу буудайн тарианд үүрлэсэн нь», «Сайн харвах нь», «Хөгшин арслан өвчтэй гэж аргалсан нь», «Хорхой арслан лугаа мөчөөрхөн тэмцсэн нь», «Арслан өөрийгөө хуурсан нь», «Багын эхээ доромжилсон нь» гэх ёгт үлгэрүүд нийтлэгдэж, сэрэмжлэн хичээх, бүлгэмдэн нягтрах, муугаа халж сайныг сурах, жич ховдог сэтгэл ба атгаг сэтгэлийг тэвчих, номхон даруу байх зэрэг ёс учрыг ухуулахын дагуу Орос, Японы зусар арга ба мэхийг сэрэмжлэн хичээхгүй бол «хараацай» мэт үүргээ «бялзуухай»-д булаалгах, «шувуу» буюу «хурга хонь» мэт «муур» ба «чоно»-нд идэгдэх аюултай болохыг ёгтлон сургажээ.

«АЙЛТГАСАН УЧИР»-т голдуу Монголыг харгалзах, гадаад улсаас зоос зээлэхэд айлтгах, худалдааны мухлаг нээх, сургууль байгуулах, өртөө байгуулж зам нэвтрүүлэх, ашгийг дэгжүүлэн хязгаарыг батлах, иргэнийг нүүлгэх, атар газар тэгшлэх Монголын аж үйлсийн компани эрхлэх, Монголын уурхай булгадацыг нээх, Монголын цааз засгийг байгуулах, монгол вангийн зэрэг хэргэм залгамжлах зэрэг хэрэг учрын тухай, бичгийн яам, гадаадын хэргийг шийтгэх журган, монгол явдлын яам, цаазын яам зэрэг байгууллага, нэгжийн «айлтгал», «нугалбар», «эвхмэл»-үүдийг нийтэлжээ. Эдгээр айлтгалуудын зонхи нь Чин гүрний «Шинэ засаг»-ийн агуулгад холбогдож буй.

«З» ЭЭЛИЙН ЮМНЫ ҮНЭ»-д Гирин мужийн сар болгоны зээлийн мөнгө, мөнгөн зоос, нэрэм будаа, гурил, бурцаг, шишийн «мөнгө амуугийн цагийн үнийн хуудас»-ыг нийтэлж, «Монголчууд эд мөнгө авахдаа зальхай хулдаанд мэхлэгдэх»-ээс сэрэмжлэхэд зориулж байжээ.

«ЭРТНИЙ ЯВДАЛ» буланд нийтэлсэн «Монголын уг явдал»-д Монголын мандсан түүхийг Чингисийн дээдэс Бодончараас эхэлж үргэлжлэн нийтэлж, «Түмэн улсын ойрх ертөнцийн явдал»-д гадаад улсуудын ойрын түүхэн хэрэг учрыг танилцуулжээ.

«НЭМСЭН ЗУРАГ»-т «Ше ме вэ гүн», «Чоно нохойг хуурсан нь», «Нохой махыг зуусан нь», «Хоёр хүн гөрөөсөнд тохиолдсон нь», «Айлын эхнэрүүд сахиулсныг итгэсэн нь», «Өлөгчин нохой газар зээлсэн нь», «Бүлгийн бага хөвгүүд бөмбөг жанчих нь», «Тагтаа хараацай лугаа», «Хожмын зовлонг

сэргийлэх», «Сүрэг хонь нохойн ачийг хариулсан нь», «Хоёр барс сэхээ орсон», «Сохор өвгөний дийлэн өгүүлсэн нь», «Цэрэг анги болж наадсан нь», «Ховдгийг цээрлэсэн нь», «Ах дүү хичээн сурах», «Хичээн сурваас олж хөхүүлмүй», «Бага хүүхэд биширтэл хэлсэн нь», «Эхийн төв чанга сургасан нь», «Үнэг арга гаргасан нь» зэрэг үлгэрүүдэд зурмал зураг хавсарган нийтэлж, арга дэмийг эрхэмлэх хичээмтгий болгоомжтой байх зовлонгийн дунд нөхрийн үнэнийг мэдэх, бурханыг итгэхээр биеэ итгэх зэрэг гүн агуулга, ёс учрыг амьд дүрслэлээр илтгэсэн бөгөөд Орос, Японыг сэргийлэхгүй юм бол хурга, манасан «нохой», чадалгүй «тагтаа» мэт «чоно» ба «хараацай»-д хуурагдан идэгдэх буюу «адуучин хүн» мэт «өлөгчин нохой»-д газраа зээлж өгөөд буцаан авчрахад бэрх болно гэж дамаар сэрэмжлүүлж байв.

«ИЛҮҮЦ ЗҮЙЛ»-д «Иргэчүүдийн эргүүг унших нь» гэх тайлбарлан өгүүлсэн зохиолыг нэгдүгээрээс арваннэгдүгээр удаагийн дэвтэр болтол үргэлжлэн нийтэлж, хууль цааз тогтоох ба газар орон өөртөө засах, жич иргэдийн эрхийн тухай асуудлуудыг тайлбарлажээ. Арван хоёроос арвангуравдугаар удаагийн дэвтэрт тухайн үед хэрэгжүүлж байсан түшмэлийн дүрмийг танилцуулжээ. «Арвантавтай бага сайн эрчүүд» хэмээх өгүүллэгийг арвандөрвөөс хориннэгдүгээр удаагийн дэвтэрт цувруулан нийтэлж, «Эв, Мей улсын шударга төвшин сайхныг хэлсэн нь» гэх нийтлэлийг хоринхоёроос хоринтавдугаар удаагийн дэвтэрт тохируулаад Европ, Америкийн улсуудын ардчиллын үзэл санаа, нийгмийн эмх дэглэмийг дагах суртал ба

цаг мөчийг завдах, бусдыг хүндэтгэх сайхан мораль-ийг танилцуулжээ.

Үүнээс гадна уг сэтгүүлд «Өөр зүйлийн үлэмж сонсгол» гэж байж, сэтгүүл эрхэлсэн зорилт, сэтгүүлийн онцлогоо танилцуулах буюу сэтгүүлд эх бичиг элсэх ба сэтгүүлийг захиалах зарыг талбисан байдаг. «Уул бодоролын тушаалын захиргаа»-нд сэтгүүлд ажиллагсдын нэр ба тушаалыг тодорхойлж буй.

Хоёр. Дүгнэлт

«Монгол үгийн бодорол» сэтгүүл сар бүр 700 хувь дармаллагдаж Гирин мужид харьяалагдах монгол хошууны эл газрын монголчуудад үнэ төлбөргүйгээр тархааж байв⁷. Үүнээс гадна «Хэрэв нэмж үзэх буй аваас нэгэн дэвтэр бодоролыг найман жиюүгээр тогтоож, хялбар үнээр үзэж байх болбаас даруй манай газраа захидал ирэхийг хүсмүй. Түүний ёсоор хүргэтүгэй» гэж буй.

Тус сэтгүүл Гирин мужийн Дайчлан байцаах хороо «Монголын явдлыг шийтгэх газар»-ын албанаас эрхэлсэн сэтгүүл болсны хувьд тухайн үеийн төр засаг — Чин гүрний санаа зорилтыг тусгах нь дамжиггүй юм.

1 ■ «Монгол үгийн бодорол» нийтлэлийн төрөл, зүйлийн хувьд хэдийгээр ерөнхийлсөн чанартай сэтгүүл болох боловч үндсэн агуулга ба үндсэн чиглэлийн хувьд харин Орос, Японоос монголчуудыг өөртөө татаж, Монгол орныг хүчний хүрээ болгож хэсэглэн эзэрхэх гэсэн түгшүүрт түүхэн ахуй байдалд чиглэгдэж эрхлэгдсэн болохоор тус сэтгүүл бол улс төрийн өгүүллийн сэтгүүл болно.

2. Сэтгүүлийн эл бүлэг дэх нийтлэлүүдийг ажиглавал хааны «Эрдэм сэт-

гэл»-ийг ухуулан дэлгэрүүлэх ба Монгол орныг эзэрхэх Орос, Японы «санаа»-г илчлэхийг бараг буй бүхий бүлгийн төрөл бүрийн нийтлэлд уусган шингээж, үүгээр дамжиж Монгол орон дахь Орос, Японы нөлөөний өргөжлийг хориглож, Дундад улсын Монгол орон дахь эрх мэдлийг батлах зорилт талбисан нь илэрхий байна.

3. Сэтгүүл илэрсэн шарын шашныг хязгаарлах, соёл, сурган хүмүүжлийг хөгжүүлэх зам засч, уурхай булагдац нээх, аж үйлс эрхлэх, атар газрыг ашиглаж тариаланг хөгжүүлэх тухай нийтлэлүүд нь Монгол оронд хэрэгжүүлэн туушлуулж байсан Чин гүрний төрийн бодлого чиглэлтэй яг эсэргүү биш, харин эдгээрээр агуулгаа болгосон «Шинэ засаг»-ийг сурталчилж, Чин гүрний санаа зорилтыг идэвхтэй тусгаж байсныг харуулж буй.

4. Тус сэтгүүлийг хэдийгээр Орос, Японы нөлөөний өргөжлийг хориглож, Монгол орон дахь Дундад улсын эрх мэдлийг батлах зорилгоор эрхэлж байсан боловч монголчуудад тухайн үеийн улс төр, нийгмийн байдлыг ойлгуулах, мэдээ занги хангах, амьдралын гүн агуулга ёсыг таниулах, шинжлэх ухааны мэдлэг олгох, өөрийн хүчээрээ улс орноо хөгжүүлэх бодлого ургуулах, ардчиллын үзлийг төрүүлэхэд ашигтай эерэг зүйл нийтэлж байсныг үгүйсгэж болохгүй.

5. «Монгол үгийн бодорол» хэдийгээр улс төрийн өгүүллийн шинжтэй ерөнхийлсөн сэтгүүл боловч «Цагийн хэргийн чухал сонсгол» бүлэгт их хэмжээний сонин мэдээ нийтэлжээ. Эдгээр сонин мэдээллүүд нь тухайн цаг үеийн зам харилцааны буйд бөглүү,

чимээ холбооны нөхцлийн хоцронгуйгаас болж цагийн цагч чанараар төдий чанга бус боловч олонх нь сонин мэдээний «5W&H»-ийг бүрэлдүүлж, сонин мэдээний үнэ өртгөөр ч нэлээд өндөр байгаа болохоор уг сэтгүүлийг сонин мэдээний шинжээр нэлээд товойм гэж үзэж болно.

6. Тус сэтгүүл нүүрийн хувисаа гоёлон урлаж, гоо сайхан хөвөөлөмж оруулж, гүн ухаалаг үлгэрүүдэд зураг зурмал хавсаргаж сонирхолт чанарыг нэмэгдүүлснээр барахгүй «Өөр зүйлийн үлэмж сонсгол»-доо сэтгүүл эрхэлсэн зорилт, сэтгүүлийн онцлогоо танилцуулах буюу сэтгүүлд эх бичиг элсэх ба сэтгүүл захиалахаар талбисан байдаг. Анхны үеийн монгол сэтгүүлийн нэгэн болсны хувьд энэ нь хожмын сонин сэтгүүл эрхлэгчид зар сурталчилгааг чухалчлах ба сонин сэтгүүлийг чимэх талаар дуурайл болсон нь лавтай.

7. Уул сэтгүүлийг хятад хэлээр бэлтгээд монголд орчуулдаг байсан болохоор орчуулгын хэл хэллэг нэлээд хөшүүн, зарим үг, өгүүлбэрийг хэрэв хятадтай нь харьцуулж үзэхгүй юм бол ойлгомж муутай байдгийг энд дурдах ёстой.

Тайлбар: «Монгол үгийн бодорол» сэтгүүлийн дугааруудыг Японы Шиюва охидын их сургуулийн профессор Хөхбаатар гуай харамгүй, харамжгүйгээр хангасанд талархаж байна. Сэтгүүлийн адил бус дугаарын хувисан дээр нэрийдлээ «Монгол үсгийн бодорол», «Монгол үгний бодорол», «Монгол үгийн бодорол» гэж гурван зүйлээр бичиж буй.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. «Монгол үгийн бодорол». Гуравдугаар удааны дэвтрийн «Өөр зүйлийн үлэмж сонсгол»-д
2. «Монгол үгийн бодорол». Аравдугаараас хорингуравдугаар, Хорингуравдугаар дэвтрийн «Уул бодоролын тушаалын захиргаа»-нд
3. «Монгол үгийн бодорол». Нэгдүгээр удааны дэвтрийн «Монгол үсгийн бодоролыг тархаан үзүүлэх нь»-д
4. «Монгол үгийн бодорол». Хоёрдугаар удааны дэвтрийн «Энэ бодоролын өөр байдал»-д.
5. «Монгол үгийн бодорол». Арвандолоодугаар удааны дэвтрийн «Өөр зүйлийн үлэмж сонсгол»-д.
6. Төгсцөгт, Вэн Сиү Лэн.

«Монгол сонин сэтгүүлийн түүхэн тойм». 63 дугаар нүүр. ӨМИС-ийн Хэвлэлийн хороо. Хөх хот. 1999.

Резюме

Настоящая статья посвящена журналу «Монгол үгийн бодорол» («Размышления монгольской словесности»), который выпускался правительством маньчжурской династии Цин специально для монгольской аудитории. При этом автор, ссылаясь на материалы, которые ещё не стали достоянием общественности, предпринял попытку осмыслить с новейших позиций цель и задачи, публикационную политику данного издания.